



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2022/289/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 315558 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ч.Ариунаа Утас: 325093 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-12
3. Аудитын тайлан	13-19
3.1 Ерөнхий зүйл	143
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	154
3.4 Материаллаг байдал.....	154
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	154-15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	155-16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	186-17
3.8 Аудитын гол асуудал.....	187
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	187-18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	198
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	209
4. Аудитын илрүүлэлт.....	209-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НА	Нотлох ажил
СА	Санхүүгийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗГ	Засгийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ЗД	Засаг дарга
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АО	Ажил олгогч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 88
танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ТУСГАЙ ТӨВИЙН ДАРГА
Ш.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

002020059

D:\Desktop\2022\Work\Report\2022.02.21.NHTTev.docx

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,170,892.20	109,419,968.24
33	АВЛАГА	89,000.00	2,623,418.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	89,000.00	2,623,418.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,081,892.20	106,796,550.24
351	Түүхий эд материал	32,449,886.85	47,295,323.19
35110	Тусгай зориулалттай материал	29,636,800.01	41,558,150.00
35130	Эм боох материал	2,813,086.84	5,737,173.19
354	Хангамжийн материал	38,632,005.35	59,501,227.05
35410	Бичиг хэргийн материал	522,400.00	1,124,300.00
35420	Аж ахуйн материал	1,484,660.00	2,695,930.00
35440	Түлш, шатах тослох материал	3,851,280.00	4,047,500.00
35450	Барилгын засварын материал	414,000.00	315,000.00
35460	Хүнсний материал	21,466,559.35	35,280,891.05
35470	Бусад хангамжийн материал	10,893,106.00	16,037,606.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	895,736,510.34	867,725,318.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	895,736,510.34	867,725,318.11
392	Биет хөрөнгө	662,216,490.34	634,205,298.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	541,743,891.16	568,276,891.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,224,244.56)	(61,136,613.23)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,162,637.12	137,891,646.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,650,550.63)	(59,200,368.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,892,356.40	84,056,232.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,210,599.15)	(35,682,489.79)
39217	Ном	503,000.00	-
393	Биет бус хөрөнгө	233,520,020.00	233,520,020.00
39301	Програм хангамж	682,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(682,000.00)	(682,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	233,520,020.00	233,520,020.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	966,907,402.54	977,145,286.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	131,987.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	131,987.00	-
413	Өглөг	131,987.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	89,000.00	-
4136	Бусад өглөг	42,987.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	42,987.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	966,775,415.54	977,145,286.35
51	Засгийн газрын хувь оролцоо	966,775,415.54	977,145,286.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,815,684.00	91,815,684.00
51101	Өмч: - төрийн	91,815,684.00	91,815,684.00
512	Хуримтлагдсан үр дүн	872,919,440.26	883,534,563.77
51210	Өмнөх үеийн үр дүн	872,919,440.26	873,164,692.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	10,369,870.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,040,291.28	1,795,038.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	966,907,402.54	977,145,286.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,131,154,773.00	701,216,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	541,119,633.00	22,136,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	541,119,633.00	22,136,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	541,119,633.00	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	22,136,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	590,035,140.00	679,080,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,761,540.00	100,877,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,321,540.00	700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,025,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,415,000.00	100,177,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	485,273,600.00	578,202,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	485,273,600.00	578,202,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	601,057,901.15	690,343,529.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,057,901.15	690,343,529.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,265,686.62	608,770,619.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,208,744.00	258,937,936.00
210101	Үндсэн цалин	148,384,948.00	150,615,462.00
210102	Нэмэгдэл	73,905,012.00	75,459,592.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,777,000.00	20,690,700.00
210104	Урамшуулал	11,141,784.00	12,172,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,686,516.77	34,007,168.38
210201	Тэтгэврийн даатгал	23,224,995.73	24,330,074.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,156,599.06	2,600,945.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,831,702.30	2,082,435.99
210204	Ажилгүйдлийн даатгал	435,115.52	454,647.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,038,104.16	4,539,065.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,688,653.64	26,619,485.80
210301	Гэрэл, цахилгаан	16,143,279.60	16,683,240.28
210302	Түлш, халаалт	8,374,298.57	9,579,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,171,075.47	357,245.52
2104	Хангамж, бараа материалын зардал	22,492,524.56	20,695,059.88
210401	Бичиг хэрэг	2,825,223.00	1,630,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,528,020.00	1,394,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,114,791.56	3,965,049.88

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,820,000.00	3,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,204,490.00	10,285,030.00
2105	Нормативт зардал	175,787,753.09	195,115,076.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,947,500.59	11,926,913.65
210502	Хоол, хүнс	139,605,852.50	142,122,613.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,234,400.00	41,065,550.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,105,300.00	2,502,200.00
210604	Урсгал засвар	4,105,300.00	2,502,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,219,885.99	8,826,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,219,885.99	7,850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	170,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,076,308.57	62,066,792.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,477,100.00	878,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	254,000.00	3,680,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,345,208.57	57,508,192.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,792,214.53	81,572,910.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,740,000.00	14,480,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	12,380,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,740,000.00	2,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,052,214.53	67,092,710.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,252,028.03	63,730,458.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,800,186.50	3,362,252.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	530,096,871.85	10,872,870.81
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	503,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	503,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	530,096,871.85	10,369,870.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	342,822,568.41	390,754,043.69
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	342,822,568.41	390,754,043.69
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,924,500.00	0	0	45,924,500.00

9	Тайлант үеийн үр дүн	0	0	530,096,871.85	530,096,871.85
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	2,040,291.28	872,919,440.26	966,775,415.54
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	91,815,684.00	2,040,291.28	872,919,440.26	966,775,415.54
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	245,252.70	245,252.70
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,815,684.00	2,040,291.28	873,164,692.96	967,020,668.24
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-245,252.70	0	-245,252.70
19	Тайлант үеийн үр дүн	0	0	10,369,870.81	10,369,870.81
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	883,534,563.77	977,145,286.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	591,108,140.00	679,080,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	591,108,140.00	679,080,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,834,540.00	100,877,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,321,540.00	700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,025,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,415,000.00	100,177,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,073,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	485,273,600.00	578,202,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	485,273,600.00	578,202,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	586,358,140.00	649,080,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	586,358,140.00	649,080,400.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	578,365,925.47	566,607,489.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,165,752.07	261,313,716.00
210101	Үндсэн цалин	145,446,671.63	154,502,511.81
210102	Нэмэгдэл	77,833,925.77	75,768,256.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,789,389.67	19,386,905.15
210104	Урамшуулал	11,095,765.00	11,626,043.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	30,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,503,592.20	33,351,293.38
210201	Тэтгэврийн даатгал	22,089,575.28	23,581,436.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,598,774.10	2,624,195.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,038,699.10	2,101,035.99
210204	Ажилгүйдлийн даатгал	434,231.76	848,409.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,342,311.96	4,196,216.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,668,503.64	26,452,985.80
210301	Гэрэл, цахилгаан	16,314,879.60	16,683,240.28
210302	Түлш, халаалт	8,182,548.57	5,287,500.00
210303	Цэвэр, бохир ус	7,171,075.47	4,482,245.52
2104	Хангамж, бараа материалын зардал	22,256,854.56	21,173,149.88
210401	Бичиг хэрэг	2,022,180.00	2,033,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,920,000.00	1,757,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,114,791.56	3,965,049.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,885,200.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,314,683.00	10,417,500.00
2105	Нормативт зардал	189,508,369.50	155,936,844.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,905,000.00	3,000,000.00
210502	Хоол, хүнс	148,385,369.50	133,036,944.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,218,000.00	19,899,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,246,353.50	61,223,400.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,246,353.50	60,246,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	170,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,016,500.00	4,656,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,762,500.00	976,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	254,000.00	3,680,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,992,214.53	82,472,910.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,940,000.00	15,380,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,380,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,940,000.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,052,214.53	67,092,710.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,052,214.53	67,092,710.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,750,000.00	30,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,750,000.00	30,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,750,000.00	30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,750,000.00	30,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,750,000.00	30,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,750,000.00)	(30,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	578,202,900.00	514,472,441.85	63,730,458.15	88.98
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	578,202,900.00	514,472,441.85	63,730,458.15	88.98
4	Бараа, үйлчилгээний зардал	530,822,700.00	499,092,241.85	31,730,458.15	94.02
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,847,300.00	255,163,718.00	3,683,582.00	98.58

6	Үндсэн цалин	145,976,300.00	148,397,513.81	(2,421,213.81)	101.66
7	Нэмэгдэл	70,417,500.00	75,768,256.04	(5,350,756.04)	107.60
8	Унаа, болон бусад нөхөн олговор	22,990,000.00	19,374,905.15	3,615,094.85	84.28
9	Урамшуулал	19,463,500.00	11,623,043.00	7,840,457.00	59.72
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,944,400.00	32,582,543.38	2,361,856.62	93.24
12	Тэтгэврийн даатгал	24,590,500.00	23,058,686.65	1,531,813.35	93.77
13	Тэтгэмжийн даатгал	2,588,500.00	2,562,695.01	25,804.99	99.00
14	ҮОМШӨ ний даатгал	2,070,800.00	2,051,835.99	18,964.01	99.08
15	Ажилгүйдлийн даатгал	517,700.00	836,109.63	(318,409.63)	161.50
16	Эрүүл мэндийн даатгал	5,176,900.00	4,073,216.10	1,103,683.90	78.68
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,194,100.00	26,452,985.80	10,741,114.20	71.12
18	Гэрэл цахилгаан	16,800,000.00	16,683,240.28	116,759.72	99.31
19	Түлш, халаалт	11,514,100.00	5,287,500.00	6,226,600.00	45.92
20	Цэвэр, бохир ус	6,480,000.00	4,482,245.52	1,997,754.48	69.17
21	Байрны түрээс	2,400,000.00	-	2,400,000.00	-
22	Хангамж, бараа материалын зардал	21,774,900.00	21,173,149.88	601,750.12	97.24
23	Бичиг хэрэг	2,033,600.00	2,033,600.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	2,260,000.00	1,757,000.00	503,000.00	77.74
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,063,800.00	3,965,049.88	98,750.12	97.57
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	10,417,500.00	10,417,500.00	-	100.00
30	Нормативт зардал	168,900,000.00	155,586,844.79	13,313,155.21	92.12
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
32	Хоол, хүнс	146,000,000.00	132,686,944.79	13,313,055.21	90.88
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	19,900,000.00	19,899,900.00	100.00	100.00
34	Эд хогшил худалдан авах	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
38	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,962,000.00	976,900.00	985,100.00	49.79
46	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	806,400.00	693,600.00	53.76
47	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	-	180,000.00	-

48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-	22,000.00	-
49	Мэдээллийн технологийн зардал	260,000.00	170,500.00	89,500.00	65.58
53	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	4,656,100.00	43,900.00	99.07
54	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	976,100.00	23,900.00	97.61
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,700,000.00	3,680,000.00	20,000.00	99.46
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,380,200.00	15,380,200.00	32,000,000.00	32.46
70	Бусад урсгал шилжүүлэг	47,380,200.00	15,380,200.00	32,000,000.00	32.46
76	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,380,200.00	12,380,200.00	32,000,000.00	27.90
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	578,202,900.00	514,472,441.85	63,730,458.15	88.98
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	578,202,900.00	514,472,441.85	63,730,458.15	88.98
104	Орон нутгийн төсвөөс	578,202,900.00	514,472,441.85	63,730,458.15	88.98
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	19.00	19.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,043,946,430.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,043,946,430.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,043,946,430.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,426,261,354.00
210604	Урсгал засвар	4,426,261,354.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	617,685,076.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	617,685,076.42
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,043,946,430.42
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,043,946,430.42
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,043,946,430.42
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,877,500.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,877,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,515,248.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,149,998.00
210101	Үндсэн цалин	6,104,998.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000.00
210104	Урамшуулал	3,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	768,750.00
210201	Тэтгэврийн даатгал	522,750.00
210202	Тэтгэмжийн даатгал	61,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	49,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	123,000.00
2105	Нормативт зардал	350,000.00
210502	Хоол, хүнс	350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,246,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,246,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,362,252.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,362,252.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,362,252.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100,877,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,877,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,177,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн анхан шатны маягт, зааврыг хөтлөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн ахлах аудитор Ч.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн. Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Тус төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд түр хоноглох байрны үйлчилгээ үзүүлэх, тэднийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, дэмжин туслах” гэж тодорхойлсон байна.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Үйлчлүүлэгч иргэдийг бичиг баримтжуулах
- Сэтгэлзүйн тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Тайлант онд Нийслэлийн дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 601,057.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 12,021.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 9,616.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,237.8 мянган төгрөгөөр буюу 1.05 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	89.0	2,623.4	2,534.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	71,081.9	106,796.5	35,714.6
Үндсэн хөрөнгө	895,736.5	867,725.3	(28,011.2)
Нийт хөрөнгө	966,907.4	977,145.3	10,237.8
Өр төлбөр	131.9	-	(131.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	966,775.4	977,145.3	10,369.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	966,907.4	977,145.3	10,237.8

Бараа материалын дансны үлдэгдэл 106,796.5 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 35,714.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь НЗД-аас олгосон нэмэлт санхүүжилтийн төсвөөс бараа материал авч, их хэмжээний нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 867,725.3 мянган төгрөг болж 28,011.2 мянган төгрөгөөр буурсан нь 13,077.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, төсвийн хөрөнгөөр 30,000.0 мянган төгрөгөөр нийтийн бие засах газар бэлтгэсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 34,137.3 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Тухайлбал: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 299,388.1 мянган төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 56,380.9 мянган төгрөгөөр өссөн, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 208,880.1 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 270,122.8 мянган төгрөгөөр буюу 64.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшил, АО-оос төлөх НДШ, нормативд зардал, бараа үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 615,115.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 599,735.2

мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 21,532.3 мянган төгрөгөөр бууруулж 578,202.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 32,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 5,612.5 мянга, нормативт зардлыг 16,100.0 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 42,700.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Тайлант онд төсөвт тодотгол хийж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 32,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 578,202.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 32,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг 578,202.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр нийслэлийн төсвөөс 578,202.9 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 514,472.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 63,730.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 514,472.4 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, АО-оос төлөх НДШ-ийн зардлыг 6,045.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,741.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 601.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 13,313.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 985.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 43.9 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 32,000.0 тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НЗД-ын захирамжаар 100,177.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, гэрээт ажилтны цалин хөлс, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт зарцуулж, үлдэгдэл 3,362.2 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад НЗД-ын захирамжаар 100,877.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийгмийн хамгааллын тусгай төв нь 2021 онд нийт 1,154,334.2 мянган төгрөгийн 63 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 62 мэдээллийг байршуулж 12,380.2 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Үүнд: Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12,380.2 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ЗГ-ын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 63,730.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулах худалдан авалт хийгдээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцээгүй, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.10.1. Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудитыг гүйцэтгэж, аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,544.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг 100 хувь барагдуулж, 9,876.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,544.2	1	1,544.2			
Зөвлөмж	5	9,876.3	5	9,876.3	-	-	-
Нийт дүн	6	11,420.6	6	11,420.6	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,280.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 503.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 706.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,447.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,623.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж хүргүүлжээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данснаас 503.0 мянган төгрөгийн ном акталсныг үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн.

4.2 Албан шаардлага

4.2.1 Тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний 3,447.7 мянган төлбөрийг И баримтгүй шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. “*Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар*”-ын 6.5. “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг хэрэгжүүлээгүй.*

4.3 Төлбөрийн акт

4.3.1 Аудитын явцад бараа материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд 8 нэр төрлийн 706.0 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан. Энэ нь ТБОНӨТХ-ийн 73 дугаар зүйлийн 73.2 “*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг*

тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” заалтыг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Авлагын асуудал

Илрүүлэлт: Гэрээт 3 ажилтанд 2022 оны 1 дүгээр сарын цалин хөлсийг урьдчилан олгож авлага үүсгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэхгүй байх

4.4.2 Анхан шатны маягт хөтлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн агуулахын бүртгэл хөтлөөгүй. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралтын 3.5 “Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө. Агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтөлнө. Түүний хуудас нэг бүрийг дугаарлан, хуудасны тоог тавьж хариуцагч нягтлан бодогч нь эд хариуцагчид жилийн эхэнд хүлээлгэн өгнө” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлж, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Акталсан үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй үнэ гарсан зардлаар бүртгэсэн.	1	503.0	1	503.0						
2	Цалин хөлсийг урьдчилан олгож авлага үүсгэсэн.	1	2,623.4							1	2,623.4
3	Анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн хөтлөөгүй.	1	-							1	-
4	Бараа материалын хяналтын тооллого хийхэд хүнсний материал дутагдсан.	1	706.0			1	706.0				
5	Зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг И баримтгүй шилжүүлсэн.	1	3,447.7					1	3,447.7		
Дүн		5	7,280.0	1	503.0	1	706.0	1	3,447.4	2	2,623.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй.	1	12,380.2							1	12,380.2
Дүн		1	12,380.2							1	12,380.2
Нийт дүн		6	19,660.2	1	503.0	1	706.0	1	3,447.4	1	12,380.2